

Монгол Улсын Шадар сайд,
Эрүүл мэндийн сайдын 2019 оны 116/565 тушаалыг үндэслэв.



ХҮҮХДИЙН СЭРГЭЭН ЗАСАХ ХАН-ТУУЛ ТӨВ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БАГИЙН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Нэг. Бүтэц зохион байгуулалтын талаар

Албан тушаал	Нэр	Ажилласан хугацаа	Ажилласан жил мэргэжлийн зэрэг
Чанарын менежер /Эмчлэгч эмч хавсран гүйцэтгэж байгаа/	С.Жаргалзаяа	2025 оны 10-р сарын 01- ний өдрөөс одоог хүртэл /2025 оны 01 сарын 02-нд тус төвд сэргээн засах эмчээр орсон./	20 жил 2000 онд АУИС эмчилгээний анги төгссөн. 2002 онд Арьс гоо заслын их эмч 2008 онд Сэргээн засах их эмч 2010 онд Зүү төөнө заслын их эмч 2016 онд АУ-ны магистр 2019 онд Зүү төөнө заслын Ахлах зэрэг 2023 онд УХТЭ,Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдлын менежер төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшилээр “Эмнэлгийн тусламжийн чанар аюулгүй байдлын менежер” ээр тус тус төгссөн. Арьсны эмчээр 4 жил, сэргээн засахын эмчээр 14 жил, чанарын менежерээр 6 жил ажилласан. 2025 оны 01 сараас Хүүхдийн сэргээн засах Хантуул төвд сэргээн засах эмчээр ажиллаж байна.

Дүгнэлт:

НЭМГ-ын даргын 2024 оны 04-р сарын 02-ний өдрийн А/36 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан Нийслэлийн хүүхдийн сэргээн төвийн бүтцэд ЭМТҮЧАБА-гүй зөвхөн чанарын менежер ажиллах юм. 2025 оны 10 дугаар 01-ны төвийн даргын Б/42 тушаалаар албажин чанарын менежерийг түр хавсран гүйцэтгэж байна.

Хоёр. Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд тогтмол хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр

№	Хяналт шинжилгээ үнэлгээний чиглэл	Хийгдсэн үйл ажиллагаа талаар	Хяналт үнэлгээний үр дүн
1.	Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах журмын хэрэгжилтэд хяналт хийх	Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулахтай холбоотой гарсан алдах дөхсөн 8 тохиолдол дээр үндэслэн тус журмын хэрэгжилтэд хяналт хийж, 3 удаагийн зааварчилгааг эмч, ажилтнууд нийт 42 хүнд өгсөн .	“Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах журам”-ын хэрэгжилтэд хяналт хийж, зааварчилгаа өгснөөс хойш эмийн аюулгүй байдалтай холбоотой тохиолдол давтан бүртгэгдээгүй. Хэрэгжилт-91%
2.	Ижил мэргэжилтний үнэлгээ хийх	Төвийн даргын 2022 оны 10 сарын 27-ны өдрийн А/42 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Ижил ижил мэргэжилтний үнэлгээний хуудас”-аар өвчний түүхэнд үнэлгээг улиралд 1 удаа хийж дүгнэдэг.	-Эмч нарын өвчний түүх бичилт 85%, -Сувилагч нарын үнэлгээ 80%, -Хөдөлгөөн, хөдөлмөр засалчийн үнэлгээ 85%-тай тус тус байна.
3.	Төвийн үйл ажиллагаа, үзүүлж буй тусламж, үйлчилгээнд тохирсон чанар, аюулгүй байдлыг хэмжих үндсэн болон өвөрмөц шалгуур үзүүлэлтүүдээр үнэлж, дүн шинжилгээ хийх	Хүүхдийн сэргээн засах Хантуул төвийн тусламж үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлтийг төвийн даргын 2026 оны А/14 тушаалаар чанарын шалгуур үзүүлэлтийг бодох аргачлалыг хавсралтаар тус тус боловсруулан батлуулсан.Тусламж үйлчилгээний төрөл бүрийг хамруулан нийтлэг 18 үзүүлэлтээр, өвөрмөц 3 шалгуур үзүүлэлтээр /нийт -22/ үнэлгээг улиралд 1 удаа хийсэн.	2026 оны эхний улиралд Өвөрмөц 3 шалгуураар үнэлгээ хийхэд : Хөдөлгөөн засал, Хэл засал -90% Эхний хагас жилд тоног төхөөрөмжийн хангалт хийгдээгүй байна.

Гурав. Чанар сайжруулах чиглэлээр ажилтнуудад сургалт, харилцан туршлага солилцох ажлыг тогтмол зохион байгуулж, тасралтгүй суралцах үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр

3 Чанар сайжруулах аян 1 удаа хийж, 38 хүн хамрагдсан.

№	Аяны сэдэв	Аяны хугацаа	Оролцсон хүний тоо	Хийгдсэн үйл ажиллагаа	Үр дүн
1.	“Миний мэдэх сувилагч” олон улсын сувилагчийн өдрийг угтсан арга хэмжээ	5 сар	Эмч, сувилагч, хөдөлгөөн, хөдөлмөр засалч нийт 32 хүн	ЕБС-ын 18-р сургуулийн ахлах ангийн 200 хүүхдэд эссе бичлэгийн уралдаан зарлаж 3 эссе шалгаруулж өргөмжлөл үнэ бүхий зүйлийг дурсгасан.	Сувилагч мэргэжилтний үнэ цэнэ ач холбогдлыг сурталчилж, түгээн дэлгэрүүлсэн.
2.	“Халдвараас сэргийлье” уралдаан, АХА тэмцээн	14 хоног	Эмч, сувилагч, хөдөлгөөн, хөдөлмөр засалч, ажилтнууд нийт 36 хүн	“Халдвараас сэргийлье” уралдаан, АХА тэмцээнийн удирдамжийн дагуу зохион байгуулсан.	Уралдааны үр дүнд тасгууд ЭТҮХХ-аас сэргийлэх 10-аас дээш бүтээлч ажил хийсэн. АХА тэмцээнд эмч М.Баярмаа түрүүлсэн.
3.	Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчинг бүрдүүлье	4сар	Нийт эмч нар, бусад ажилтан, албан хаагч-3 6	Төвийн дотор талын 2 давхрын шатанд унах эрсдлээс сэргийлж бариул хийсэн. -Ажиллагсад болон үйлчлүүлэгчид хальтрах эрсдэл, цахилгааны эрсдэлийг бууруулах арга хэмжээ авсан.	Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангасан ээлтэй орчинг бүрдүүлсэн.
4	“Мэргэжил бүхэн сайхан” аян Сувилахуйн багаас зохион байгуулсан.	05 сар	Нийт эмч нар, бусад ажилтан, албан хаагч-34	Олон улсын сувилагчдын баярыг тохиолдуулан 5 хоногийн аяны хүрээнд Байгууллагын үйл ажиллагаа болон сувилагч мэргэжлийн үнэ цэнэ ач холбогдлыг сурталчилсан, эрүүл мэндийн боловсрол олгосон.	Тусламж үйлчилгээ, эмчилгээнд ахиц гарсан. Эмч мэргэжилтнүүдийн Мэдлэг чадвар сайжирсан.

3.2 Разбор –хэлэлцүүлэг 2 удаа оролцсон.

- Бяцхан тэмүүлэл төвөөс зохион байгуулсан Кейс хэлэлцүүлэгт “Жингийн алдагдалтай хүүхдүүдэд илчлэг нэмэгдүүлсэн хоол тэжээлийн нөлөө” сэдвээр хүүхдийн эмч Г.Сэржхорлоо, ахлах сувилагч Н.Сарангэрэл, хоолны технологич Ү.Мөнхгэрэл, статистикч Б.Алтанцэцэг нар илтгэл хэлэлцүүлж амжилттай оролцсон болно.
- Нийслэлийн ХСЗ Бяцхан тэмүүлэл төвөөс зохион байгуулсан Кейс хэлэлцүүлэгт “Хүүхдийн хэл засал, эмчилгээний үеийн тохиолдол” сэдвээр хэл засалч С.Жаргалнэмэх илтгэл хэлэлцүүлж амжилттай оролцсон.

3.3 Илтгэл ,судалгаа: 3 хийгдсэн.

- Бяцхан тэмүүлэл төвөөс зохион байгуулсан Кейс хэлэлцүүлэгт “Жингийн алдагдалтай хүүхдүүдэд илчлэг нэмэгдүүлсэн хоол тэжээлийн нөлөө” сэдвээр хүүхдийн эмч Г.Сэржхорлоо, ахлах сувилагч Н.Сарангэрэл, хоолны технологич Ү.Мөнхгэрэл, статистикч Б.Алтанцэцэг нар илтгэл хэлэлцүүлж амжилттай оролцсон болно.
- Нийслэлийн ХСЗ Бяцхан тэмүүлэл төвөөс зохион байгуулсан Кейс хэлэлцүүлэгт “Хүүхдийн хэл засал, эмчилгээний үеийн тохиолдол” сэдвээр хэл засалч С.Жаргалнэмэх илтгэл хэлэлцүүлж амжилттай оролцсон.
- “Овьёосны ванн эмчилгээ” хүний биед ямар ач холбогдолтой сэдвээр “Зууны Манлай” сонины 2026 оны 03 дугаар сарын 18-ны дугаар дээр хэвлэж нийтлүүлсэн.

3.4 Бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт - 6 удаа

№	Сэдэв	Хамтран ажилласан байгууллага	Оролцсон тоо	Хэзээ	Гарсан үр дүн
1.	“Амилуулах суурь тусламж” сургалтыг хийсэн.	УХТЭ-Яаралтай тусламжийн тасаг	36	2026 оны 05 сарын 19-ны өдөр	“Хүүхдийн эрэмбэлэн ангилалт” “BLUE CODE”, “Амилуулах суурь тусламж”-ийн талаар мэдлэгтэй болж, зарим гардан үйлдлийг хийж сурсан.
2.	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, тохиолдол, эрсдэл	Эрүүл мэндийн чанарын холбоо	38	2026 оны 05-р сарын 01-08 ны өдөр	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал-ын тухай мэдлэг нэмэгдсэн.Холбогдох тушаал журмыг дагаж мөрддөг болсон.
3.	Хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх үзлэг.	ХУД-н 72-р цэцэрлэгийн 3 балбар	313	2026 оны 03-р сарын 10-14 ны өдөр	2026 оны эхний улиралд төвийн сэргээн засах эмч, хүүхдийн эмч, нийгмийн ахжилтан нарын бүрэлдэхүүнтэй баг томилогдож удирдамжийн дагуу ХУД-ийн 72-р цэцэрлэгийн 3 салбар дээр эрт илрүүлгийг зохион байгуулсан. Хүүхдийн хөгжлийн эрт

					илрүүлэг болон эрүүл мэндийн үзлэг зөвлөгөөнд 1,5-5 насны нийт 313 хүүхэд хамрагдсан.
4.	Аутизмыг таниулах дэлхийн өдөр	Монголын аутизмын холбоотой хамтран	24	2026 оны 04 дугаар сарын 02-ны өдөр	Аутизмыг таниулах дэлхийн өдрийн угтаж 03 дугаар сарын 18-ны өдөр Монголын Аутизмын холбоотой хамтран сургалт, мэдээллийн үйл ажиллагаа, Дэлхийн Дауны өдрийг угтан 04 дүгээр сарын 02-ны өдөр Дауны холбоотой хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх асран хамгаалагч, ерөнхий боловсролын 18, 52, 75 дугаар сургуулийн Дэмжлэгийн багийн гишүүд, Хан-Туул төвийн эмч, ажилтны төлөөллийг хамруулан нийт 71 иргэнийг хамруулан сургалт зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх асран хамгаалагч нар болон эмч ажилтнуудын мэдлэг чадвар
5	Дэлхийн Дауны өдөр	Дауны холбоотой хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх асран хамгаалагч нарт	24		
6	Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаарх сургалт	ХУД-ын онцгой байдлын хэлтэс	34	2026 оны 03 дүгээр сарын 26-ны өдөр	ХУД-ийн Онцгой байдлын хэлтсийн мэргэжилтэн ирж зохион байгуулсан. Нийт 35 ажилтан, албан хаагчид хамрагдсан

3.5 Үзүүлэх сургууль-2

- Төвийн чанарын багийн санаачлагаар Цэнхэр код идэвхжүүлсэн 1 удаагийн үзүүлэх сургууль зохион байгууллаа.

Үзүүлэх сургуульд 33 мэргэжилтэн оролцсон.

- Төвийн халдварын сэргийлэлт хяналтын багаас “Халдвараас сэргийлье” АХА тэмцээн 1 удаа нийт 34 хүн оролцсон.

2026 оны 04 дугаар сарын 27- ний өдөр нийт ажилчдын дунд халдварын сэргийлэлт, хяналтын талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилготойгоор зохион байгуулсан.

3.6 Өдөрлөг -2

- НЭМГ-с зохион байгуулсан Байгууллагаа сурталчлах өдөрлөгт 3 хүний бүрэлдэхүүнтэй баг 2026 оны 03 сард нийт өдөр амжилттай оролцсон.

- “Мэргэжил бүхэн сайхан” аян Сувилахуйн багаас 05/05-05/09 хооронд зохион байгуулсан. Олон улсын сувилагчдын баярыг тохиолдуулан 5 хоногийн аяны хүрээнд Байгууллагын үйл ажиллагаа болон сувилагч мэргэжлийн үнэ цэнэ ач холбогдлыг сурталчилсан, эрүүл мэндийн боловсрол олгосон. Нийт-34 ажилтан оролцсон.

Дүгнэлт: Магадлан итгэмлэлийн хугацаа сунгах ажлын хүрээнд төлөвлөгөөний дагуу 2026 оны эхний улиралд Аян 1 удаа, АХА тэмцээн 1 удаа тус тус зохион байгуулсан. Эрүүл мэндийн чанарын холбоо, УХТЭ-ийн Яаралтай тусламжийн тасагтай хамтран дээрх чиглэлээр 2 удаагийн том хэмжээний сургалтанд давхардсан тоогоор 84 эмч, мэргэжилтэн, ажилтан хамрагдсан.

Дотооддоо ажлын байрны тасралтгүй сургалтанд эмч, мэргэжилтний мэргэжлийн ур чадавхийг дээшлүүлэх 8 удаагийн сургалтанд 124 орчим мэргэжилтэн давхардсан тоогоор хамрагдсан.

Эдгээр сургалтын үр дүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээг аюулгүй, чанартай, үр дүнтэй, хүртээмжтэй, үйлчлүүлэгч төвтэй үзүүлж байна.

Дөрөв.Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг хангах, үнэлэлт дүгнэлт өгөх, түүний мөрөөр цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах чиглэлээр

Чанар сайжруулах төлөвлөгөөг 2026 онд 10 чиглэлээр 59 ажил төлөвлөж батлуулсан. Хэрэгжилт 90 % -тай байна.

№	ЭМТҮЧАБ-ын багийн хурал	Хийсэн хугацаа	Хэлэлцсэн асуудлын тоо	Шийдвэрлэсэн асуудал
1.	Магадлан итгэмжлэлд орох бэлтгэл байдлыг хангах	2026 оны 01-р сарын 10-ны өдөр	5	Бэлтгэл байдлыг хангах ажлын чиглэл өгсөн.
2.	Магадлан итгэмжлэлийг сунгуулах материалыг ЭМХТ рүү өгөх	2026 оны 04-р сарын 14-ны өдөр	8	Шалгуур бүрт материалыг бүрдүүлж ЭМХТ-ийн цахим хүсэлтэд байршуулах
3.	Магадлан итгэмжлэлийн шинжээчдэд ажлын байраа шалгуулах бэлтгэл байдлыг ханган ажиллах	2026 оны 05-р сарын 27-ны өдөр	15	Магадлан итгэмжлэлийн шинжээчдэд ажлын байраа шалгуулахад бүх тасаг нэгж 100% бэлдэх

Тав. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж зааврыг мөрдүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах чиглэлээр.

ЭМТҮЧАБ-ын багийн чанарын менежерийг 2025 оны 10 сарын 01-ны өдрийн Б/42 тоот тушаалаар баталсан.

Хүүхдийн сэргээн засах Хантуул төвийн тусламж үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлтийг төвийн даргын 2023 оны А/58, чанарын шалгуур үзүүлэлтийг бодох аргачлалыг боловсруулан 2026 оны А/14 тушаалаар батлуулсан. Тусламж үйлчилгээний төрөл бүрийг хамруулан нийт 22 үзүүлэлтээр, үүнээс өвөрмөц 3 шалгуур үзүүлэлтийг гаргасан.

Чанарын багийн дотоод хяналтыг 12 чиглэлээр хяналт хийх үйл ажиллагааг гарган ЭТҮХОД-оор батлуулсан. Үүнд:

- 2026 оны 03-р сард эмч сувилагч нарт хийт 2 удаагийн ижил мэргэжилтэний үнэлгээг хийсэн. Өвчний түүх хөтлөлт 90 % .
- 2026 онд Эмчилгээ оношилгооны чиглэлээр 3 хяналтын хуудас шинэчлэн боловсруулсан.
- Сувилагч, нарын сувилгааны түүх, анхан шатны маягт хөтлөлтөнд ижил мэргэжилтэний үнэлгээг нийт удаа 26 картанд хийхэд хөтлөлт 83 % байна.
- Өвөрмөц 3 шалгуур үзүүлэлтэд үнэлгээг хийхэд 91% байна.

Дүгнэлт. 12 төрлөөр 36 удаагийн хяналт хийсэн.

- Өвчний түүх хөтлөлтийг сайжруулахад гарсан зөрчлийг хэлэлцэж, тухай бүрд арга зүйн зөвлөгөө өгсөн.

Зургаа. Хөндлөнгийн хяналт, шинжилгээ, үнэлгээ, магадлан итгэмжлэл, мэргэжлийн хяналтын шалгалтын дүн, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр

- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ажил дүгнэх тухай 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг НЭМГ-т хянуулан хүлээлгэн өгч 84% үнэлгээгээр үнэлэгдсэн.
- 2024.07.21- 2026.07.21нд Магадлан итгэмжлэлийн үнэлгээнд хамрагдаж 2 жилээр сунгагдсан. /Батламжийн Дугаар-208/2024 / 2026.05.27-нд Магадлан итгэмжлэлийн 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирж үнэлгээ хийсэн.
- Байгууллагын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан балансыг 2026 оны 01 дүгээр сарын 25-ны дотор Сангийн яамны Е-тайланд шивж оруулан мэдээлсэн. Мөн НЭМГ-т хуваарьт өдөр, хугацаанд нь тайлагнаж хүргүүлсэн.
- Аудитын хөндлөнгийн хяналт 2026 оны 03 сард орсон.
- 2026.06.05-нд НЭМГ-с MNS7014:2023 стандартын хэрэгжилтийн хяналт шалгалтанд хамрагдсан.

Долоо.Эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй халдварын сэргийлэлт, хяналтын, эмчилгээний, ёс зүйн, эмийн, болон бусад хороо, зөвлөл, албадуудтай хамтран ажиллан, үйл ажиллагаанд хяналт тавьж, чанар сайжруулах үйл ажиллагаанд татан оролцуулах талаар

7.1 Эмч ,эмнэлгийн мэргэжилтэний харилцаа хандлага, ёс зүйг сайжруулах чиглэлээр хийсэн ажлууд

№	Дотоод сургалт	Сэдэв.	Хийсэн өдөр сар	Хамрагдсан ажилтаны тоо	Үр дүн
1.	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний тухай ЭМС-ын 2019 оны А/406 тоот тушаалын хэрэгжилт	2026.03.11	26	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний тухай ЭМС-ын 2019 оны А/406 тоот тушаалын хэрэгжилт сайжирсан.
2	Халдварын сэргийлэлт хяналт	Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэл, Хог хаягдал А/173тушаал	2026.04.28	34	Халдварын эрсдэл буурсан.
3	Халдварын сэргийлэлт хяналт	Гар угаах, халваргүйжүүлэх	2026.05.05	34	Халдварын эрсдэл буурсан.
4	Халдварын сэргийлэлт хяналт	Эмч эмнэлгийн ажилчдын гарын эрүүл ахуй сахих 5 мөч	2026.05.15	36	Халдварын эрсдэл буурсан.

2026 оны эхний улиралд төвийн ёс зүйн хороо шинэчлэгдсэн.байдлаар “Ёс зүйн хэсгийн хороо”-нд хандсан иргэнээс 1 өргөдөл гомдол ирсэнийг тухай бүр шийдвэрлэн ажилласан. Ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж нийт 1 удаа ёс зүйн сургалтыг төвийн бүх эмч эмнэлгийн ажилчдад хийсэн.

7.2 Цусны аюулгүй байдлын талаар

ЭМС-ын 2024 оны А/256 дугаар тушаал шинэчлэгдэн гарсантай холбоотойгоор нийт 12 эмч сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд уг тушаалаар сургалт хийгдсэн.

7.3 Эмийн эмчилгээний хороотой хамтран хийсэн үйл ажиллагаа

№	Хамтран хийгдсэн үйл ажиллагааны төрөл/ хяналт шалгалт, сургалт, тэмцээн, хэлэлцүүлэг	Сэдэв	Хийсэн сар өдөр	Хүний тоо	Үр дүн
1	Хэвтэн эмчлүүлэх тасагт эмчилгээ тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдалд хяналт	Эм тарианы бэлэн байдал, хугацаа, хадгалалт, орлого, зарлага	01/05,03/12, 05/18	12	Хэвтэн эмчлүүлэх тасаг, яаралтай тусламжийн эмч, сувилагч нарт 9 асуудлыг сайжруулах үүрэг өгч, эргэн хяналт хийсэн. Биелэлт 100%
2	Төвийн эм тарианы зарцуулалт, хадгалалт, ЭМС-н А/352 мөрдөлтөд хяналт	Өвчний түүхийн дугаар бүрээр эмийн орлого, зарлагыг бүртгэлтэй тулгаж, эмийн хадгалалт, тэмдэглэгээ, зөв танин тодруулан эм олгож байгаад хяналт хийж зөвлөгөө өглөө.	202.05.15.	2	Сайжруулах шаардлагатай 2 асуудалд үүрэг өгч, зөвлөгөө өгөв. 2026.03.16-наас эмийн шкаф дотор зориулалтын А шүүгээнд уналт , таталтын эмийг байршуулсан.
3	Хяналт -Эм тарианы аюулгүй байдлыг хангах зорилгоор бүх термометрийг баталгаажуулах	Стандарт хэмжил зүйн газраар 4 термометрийг 1 жилийн хугацаатай баталгаажуулсан.	2026.04.14	5	Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага MNS5260:2015 стандарт мөрдөлт, эм тарианы чанар аюулгүй байдал 100% сайжирсан.
4	Сургалт: Эмийн аюулгүй байдал	Өндөр эрсдэлтэй эмийн аюулгүй байдал	2026.03.15	34	мэргэжилтэнгүүдэд танилцуулсан. Үр дүн 100%
5	Ижил дуудлагатай, ижил савлагаатай тариа, өндөр эрсдэлтэй эм тарианы хяналт	Хэвтэн эмчлүүлэх болон яаралтай тусламж, эмийн нөөцөд нэгжид тэмдэг тэмдэглэгээг сайжруулсан.	Улирал бүр	5	Өнгө ялгаж, хаяглаж байна. Бүртгэл хяналт сайжирсан. Нийт 3 удаагийн шалгалт хийгдсэн шалгалтын үр дүнд 92%

7.4 Халдварын сэргийлэлт хяналтын талаар

Халдварын сэргийлэлт хяналтын албаны жилийн ажлын төлөвлөгөөнд 3 чиглэлээр 23 ажлыг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Магадлангаас магадлангийн хооронд төлөвлөгөөт ажлууд хугацаандаа хийгдсэн. 2026 оны эхний 06 сарын байдлаар 93%-ийн хэрэгжилттэй явагдаж байна.

ЭМС-ын 2019 оны 537 тоот тушаал, Төвийн даргын 2023 оны 03 сарын 17-ны өдрийн А/26 тоот тушаалаар өөрийн төвийн үйл ажиллагааны онцлогт тохируулан 9 хяналтын хуудсыг боловсруулан батлуулсан. Батлагдсан хяналтын хуудасны дагуу 11 удаагийн хяналтыг хийгдсэн. Тус шалгуур хуудсаар давхардсан тоогоор тасаг нэгжид 8 удаа хяналт үнэлгээг хийж илэрсэн зөрчлүүдийг тухай бүр нь засуулж мэргэжил арга зүйгээр хангасан ба хяналтын хуудас нийт 9-г бичиж хэрэгжилтэнд хяналт тавьсан. Төвийн даргаар 2026 оны 1 дугаар сард ЭМТҮЧАБ-ын баг, сувилахуйн албатай хамтарсан дотоод хяналт хийх хуваарийг батлуулсан.

Төвийн даргын батлагдсан хяналтын хуудасны дагуу 9 удаагийн хяналтыг хийсэн.

1. “Эрүүл мэндийн ажилтны гар угаах, халдваргүйжүүлэх мэдлэг, дадлыг үнэлэх хяналтын хуудас”-аар 2 удаагийн хяналтаар давхардсан тоогоор 38 ажилтан хамрагдаж, дундаж үнэлгээ 85% гарсан.
2. “Гарын эрүүл ахуйг сайжруулах талаар байгууллагын үйл ажиллагааг үнэлэх хяналтын хуудас”-аар 1 удаагийн хяналт хийж 91%-тай үнэлэгдсэн.
3. “Цэвэрлэгээний чанарт дотоод хяналт хийх хуудас”-аар 3 удаагийн хяналт хийж, дундаж үнэлгээ 80%-тай байсан.
4. “Гал тогооны халдвар хамгааллыг шалгах хяналтын хуудас”-аар 2 удаагийн хяналт хийж бага эрсдэлтэй үнэлэгдсэн.

Дээрх хяналтын үнэлгээнд үндэслэж хяналтын үйл ажиллагааг тогтмолжуулж ажиллаж байна.

Агаарын халдваргүйтгэл хийх хуваарийг төвийн даргаар батлуулан гаргасан. Хувиарийн дагуу 14 хоногт нэг удаа автомаксаар 0.02%-н клорсептийн уусмалаар хийж гүйцэтгэж байна. Зөөлөн болон хатуу тоглоом халдваргүйтгэх заавар гаргаж, тус зааврын дагуу өдөр бүр халдваргүйтгэлийг тогтмол хийж байна.

“Хамгаалах хувцас, хэрэгсэл өмсөх, тайлах” сэдэвт сургалтыг 02 дугаар сард зохион байгуулж, 11 эмч, ажилчид мөн 05 дугаар сард зохион байгуулж 36 ажилчид хамрагдсан. 3 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 24 ажилчид

хамрагдсан байна. “Эрүүл мэндийн ажилтны гарын эрүүл ахуй ” сэдэвт сургалтыг 2 удаа зохион байгуулсан. Давхардсан тоогоор нийт 29 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан.

Эрүүл мэндийн ажилтны гар угаах, халдваргүйжүүлэх мэдлэг, дадлыг үнэлэх хяналтын хуудсаар 2 удаагийн хяналтыг хийсэн. Давхардсан тоогоор эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Эмч эмнэлгийн ажилчдын гарын эрүүл ахуй сахих 5 мөчлөгийн мэдлэг-88,2%, гарыг угаах дадал эзэмшсэн байдал-92% ба гарын эрүүл ахуй сахих мэдлэг дадлын дундаж түвшийн 91%-тай буюу хангалттай гэж үнэлэгдсэн байна.

Найм. Тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын талаар мэргэжлийн нийгэмлэг холбоод, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, сургалт, судалгаа хийх, туршлага судлах, зөвлөх үйлчилгээг зохион байгуулах чиглэлээр

№	Хамтран ажилласан байгууллагын нэр	Хамтран хийгдсэн үйл ажиллагааны төрөл/ хяналт шалгалт, сургалт, тэмцээн, хэлэлцүүлэг	Хийсэн үйл ажиллагааны сэдэв	Хийсэн он сар өдөр	хамрагдсан ажилтаны тоо	Үр дүн
1	Эрүүл мэндийн чанарын холбоо	Нийт 2 өдрийн 1кредиттэй сургалт	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдал	2026.05.01-.05.08	36	Тусламж үйлчилгээн д ахиц гарсан.
2	УХТЭ- Яаралтай тусламжийн тасаг	1 өдрийн дадлагажуулах сургалт	Амь тэнссэн яаралтай тусламж, Код идэвхижүүлэлт	2026.05.19	34	Тусламж үйлчилгээн д ахиц гарсан.

3	Бяцхан тэмүүлэл СЗТ	Нийслэлийн бүх хүүхдийн сэргээн засах төвүүдийн хамтарсан хэлэлцүүлэг	Нийслэлийн ХСЗ Бяцхан тэмүүлэл төвөөс зохион байгуулсан Кейс хэлэлцүүлэгт “Жингийн алдагдалтай хүүхдүүдэд илчлэг нэмэгдүүлсэн хоол тэжээлийн нөлөө” сэдвээр хүүхдийн эмч Г.Сэржхорлоо, ахлах сувилагч Н.Сарангэрэл, хоолны технологич Ү.Мөнхгэрэл, статистикч Б.Алтанцэцэг нар илтгэл хэлэлцүүлж амжилттай оролцсон болно. Нийслэлийн ХСЗ Бяцхан тэмүүлэл төвөөс зохион байгуулсан Кейс хэлэлцүүлэгт “Хүүхдийн хэл засал, эмчилгээний үеийн тохиолдол” сэдвээр хэл засалч С.Жаргалнэмэх илтгэл хэлэлцүүлж амжилттай оролцсон. Мөн “Овьёосны ванны эмчилгээ” хүний биед ямар ач холбогдолтой сэдвээр “Зууны Манлай” сонины 2026 оны 03 дугаар сарын 18-ны дугаар дээр хэвлэж нийтлүүлсэн.	2026.03.14	5	Мэдлэг чадвар дээшилсэн.
---	---------------------	---	--	------------	---	--------------------------

4	Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаарх сургалт	ХУД-ийн Онцгой байдлын хэлтэс	2026 оны 03 дүгээр сарын 26-ны өдөр ХУД-ийн Онцгой байдлын хэлтсийн мэргэжилтэн ирж зохион байгуулсан. Нийт 35 ажилтан, албан хаагчид хамрагдсан.	2026.03.26	35	Эрсдэл буурсан.
---	---	-------------------------------	---	------------	----	-----------------

Ёс. Үйлчлүүлэгчидтэй уулзалт, ярилцлага зохионбайгуулах, сэтгэл ханамжийн судалгаа явуулж, үрдүнгтооцох талаар
11.1 Үйлчүүлэгчийн сэтгэл ханамж. 2026 оны 1-р улирал

Хугацаа	Судалгаанд хамрагдсан хүний тоо				Талархал	Санал хүсэлт	Гомдол	Сэтгэл ханамжит байдал %
1-р улирал	118				28	44/18	0	94,9%
	01 сар	24	Өдөр	8	8	15	0	<u>Үнэлгээ:</u> Маш сайн - 112/ 94,9% Дунд - 6/ 5,1% Муу -0
			Хэвтэн	8				
			Хоол	8				
	02 сар	18	Өдөр	6	9	14	0	
			Хэвтэн	6				
			Хоол	6				
	03 сар	76	Өдөр	6	11	14	0	
			Хэвтэн	38				
			Хоол	32				

Арав.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах олон улсын туршлагыг нэвтрүүлнэ.

№	Олон улсын туршлагын нэр , чиглэл	Хэрэгжүүлэх талаар хийсэн ажил	Оролцогчийн тоо
1	Олон улсын стандартын академи ISO 9001 Дотоод аудитын сургалт	ISO 9001 хэрэгжүүлэх зорилготой 2026-2028 оны байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгасан.	1

Арван нэг.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний талаар эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн судалгаанд дүн шинжилгээ хийх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тулгамдсан асуудлаар чанарын судалгааг холбогдох байгууллагуудтай хамтран хийнэ.

11. 1.Эмнэлгийн ажилтын сэтгэл ханамж:

Энэхүү судалгаанд нийт 25 ажилтан хамрагдсан бөгөөд 36 асуултаар байгууллагын дотоод сэтгэл ханамжийг үнэлсэн.

2. Ерөнхий сэтгэл ханамж:Нийт оролцогчдын 68% нь эерэг үнэлгээ (сайн, маш сайн) өгсөн бол 32% нь дунд гэж үнэлсэн.

3. Ажилдаа сэтгэл ханамж:

Ажилчдын 84% нь ажилдаа сэтгэл хангалуун, 16% нь хангалтгүй гэж хариулсан.

4. Удирдлагын үнэлгээ:

60% нь эерэг үнэлгээ өгсөн боловч 36% нь дунд болон муу гэж үнэлсэн байна.

5. Ёс зүй, харилцаа:

Ажилчдын 48% нь дунд түвшинд гэж үзсэн бөгөөд 16% нь муу гэж үнэлсэн.

6. Хөдөлмөрийн бүтээмж:

60% нь дундаж, 24% нь өндөр гэж үнэлсэн.

7. Санхүү, маркетинг:

Ихэнх нь (52%) дунд түвшинд гэж үзсэн.

8. Нийгмийн хангамж:

56% нь дунд, 28% нь хангалтгүй гэж үнэлсэн.

Дүгнэлт:2026 оны эхний улиралд :Байгууллагын сэтгэл ханамж ерөнхийдөө эерэг боловч дотоод уур амьсгал, урамшууллын системд сайжруулалт шаардлагатай.

Урамшуулал идэвхжүүлэлтийн талаар санал хүсэлтүүд:

- Үндсэн цалинг нэмэх
- Ажлын үр дүнг шударгаар үнэлэх
- Цалинтай өдрийн чөлөөг урамшуулалд оруулах
- Байр, орон сууцтай болоход дэмжлэг үзүүлэх
- ХБХ-тэй ажилласан нэмэгдэл авах

Дараах чиглэлээр сайжруулах тал дээр ажиллаж байна.

-Дотоод харилцааг сайжруулах

- Урамшууллын системийг шинэчлэх

- Удирдлагын ил тод байдлыг нэмэгдүүлэх

Арван хоёр.Үйлчлүүлэгч болон эрүүл мэндийн мэргэжилтний аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс хамгаалах орчин бүрдүүлэхэд шаардлагатай зохицуулалтын талаар санал гаргаж, шийдвэрлүүлнэ.

12.1 2026 оны 1-р улиралд 8 алдах дөхсөн тохиолдол бүртгэгдсэн.

№	чиглэл	1А	1Б	2	3	алдаа
1	Үйлчлүүлэгчийг танин тодруулга		2			
2	Харилцааны дутагдал, доголдол	2				
3	Эмийн аюулгүй байдал		3			
4	Мэс заслын аюулгүй байдал					
5	эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний халдвар					
6	Эмнэлгийн орчинд үйлчлүүлэгч унасан					
7	Бусад: Эмнэл зүйн удирдамж мөрдөөгүй тохиолдол					
8	Түгээмэл үйлдлийн стандарт мөрдөөгүй тохиолдол					
9	Эрүүл мэндийн анхан шатны бичиг баримжуулалтын тохиолдол					
10	Тоног төхөөрөмжийн аюулгүй заавар мөрдөөгүй	1				

Тохиолдлыг илрүүлсэн байдал:

- эмч, ажилчдаас –5
- чанар, сувилахуй, халдвар хяналтаар хяналтаар -3

№	нөлөөлөх хүчин зүйлсийг	1А	1Б	2	3	алдаа
1	Үйлчлүүлэгчийн хүчин зүйл	2				
2	Хувь хүн/ ажилтны хүчин зүйл	3				
3	Ажлын болон үйлчилгээний орчны хүчин зүйл					
4	Багийн хүчин зүйл		2			
5	Баримт бичиг/ технологийн хүчин зүйл		1			
6	Бүтэц, зохион байгуулалтын хүчин зүйл					

Гарсан үр дагавар : байхгүй.Тохиолдол бууруулах чиглэлээр эмийн аюулгүй байдал болон зөв танин тодоулгаар нийт 2 удаа дотоод сургалт хийгдсэн.

12.2 Эрсдэлийн удирдлагын багийг Төвийн даргын 2022 оны 11 сарын 25 өдрийн А/74 тушаалаар орон тооны бус 7 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж, эрсдэлийн удирдлагийн багийн ажиллах журмыг хавсралтаар баталж, нийт 5 чиглэлт ажлыг төлөвлөн ажилласан.

- ✓ Эмчилгээ, оношлогоо, тусламж үйлчилгээтэй холбоотой эрсдэл
- ✓ Халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагаатай холбоотой эрсдэл
- ✓ Эм зүй, эм биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдалтай холбоотой эрсдэл
- ✓ Тоног төхөөрөмж, санхүү бүртгэл, мэдээлэлтэй холбоотой эрсдэл
- ✓ гадаад, дотоод орчинтой холбоотой эрсдэл

Дүгнэлт: 2026 оны эхний улирлын байдлаар Эрсдлийг 8 төрлөөр нийт 62 тохиолдож болох эрсдлийн жагсаал гаргасан. Үүнээс:Дунд түвшин -29 /46,77%/, Өндөр түвшин -19 /30,65%/, Ноцтой түвшин -14 /22,58%/ тус бүр тодорхойлсон. Эрсдлийн төлөвлөгөөний хүрээнд галын хор -4ш , архивын өрөөнд шинээр гал гарсан үед хэрэглэх иж бүрдэл -1 шинээр авч байршуулсан. Хоол үйлвэрлэлийн тасгийн цахилгааны аюулгүй байдлын эрсдлийг бууруулж ханын утсыг аюулгүй болгосон.

Арван гурав. Байгууллагын хэмжээнд чанар сайжруулах талаар хэрэгжүүлж буй бүх арга хэмжээг бүртгэн, мэдээллийн сан байгуулж олсон ололт амжилтыг байгууллагынхаа бүх тасаг/нэгжүүдэд дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулж урамшуулан ажиллана.

- Хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх үзлэг.
Эрт илрүүлэг / 2026 оны 03 сард төвийн сэргээн засах эмч, хүүхдийн эмч, нийгмийн ахжилтан нарын бүрэлдэхүүнтэй баг томилогдож удирдамжийн дагуу ХУД-ийн 72-р цэцэрлэгийн 3 салбарт эрт илрүүлгийг зохион байгуулсан. Хүүхдийн хөгжлийн эрт илрүүлэг болон эрүүл мэндийн үзлэг зөвлөгөөнд 1,5-5 насны нийт 313 хүүхэд хамрагдсан.

- Нийслэлийн ХСЗ Бяцхан тэмүүлэл төвөөс зохион байгуулсан Кейс хэлэлцүүлэгт “Жингийн алдагдалтай хүүхдүүдэд илчлэг нэмэгдүүлсэн хоол тэжээлийн нөлөө” сэдвээр хүүхдийн эмч Г.Сэржхорлоо, ахлах сувилагч Н.Сарангэрэл, хоолны технологич Ү.Мөнхгэрэл, статистикч Б.Алтанцэцэг нар илтгэл хэлэлцүүлж амжилттай оролцсон болно.
- Нийслэлийн ХСЗ Бяцхан тэмүүлэл төвөөс зохион байгуулсан Кейс хэлэлцүүлэгт “Хүүхдийн хэл засал, эмчилгээний үеийн тохиолдол” сэдвээр хэл засалч С.Жаргалнэмэх илтгэл хэлэлцүүлж амжилттай оролцсон.
- “Овьёосны ванн эмчилгээ” хүний биед ямар ач холбогдолтой сэдвээр “Зууны Манлай” сонины 2026 оны 03 дугаар сарын 18-ны дугаар дээр хэвлэж эмч сувилагчийн баг нийтлүүлсэн.
- ДЭМБ-аас АНУ-ын Autism Speaks байгууллагын дэмжлэгтэйгээр боловсруулан дэлхийн улс орнуудад түгээж буй «Хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн хоцрогдолтой хүүхдүүдийн асран хамгаалагчдын ур чадварыг сайжруулах сургалт»-ын модулийг Монголд нэвтрүүлэн нутагшуулах туршилтын төслийн хүрээнд 2 ажилтан бэлтгэгдсэн. Онолын 6 хичээлийн, гэрийн дадлага 3 удаа хийгдсэн.

Арван дөрөв. Байгууллагын цахим хуудсанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар мэдээлэл тавих, хамтын мэдээлэл солилцох, суралцах, эргэх холбооны хэрэгсэл болгох зорилго бүхийчанаар, аюулгүй байдлын буланг тогтмол ажиллуулах талаар

№	Тухайн жил байгууллагын цахим хуудсанд тавьсан мэдээллийн тоо	64
	Цахим хуудсанд хандсан хүний тоо	98000
	Чанарын буланд тухайн жилд шинэчлэж тавьсан мэдээллийн тоо	9

Арван тав. Байгууллагын тусламж, үйлчилгээтэй холбоотойгоор иргэд, байгууллагаас ирсэн санал, гомдол, хүсэлтийг шийдвэрлүүлэх ажлыг хамтран ажиллах, тэдний хүсэлтийг шийдвэр гаргалтанд тусгасан талаар эргэн мэдээлэх талаар

2026 оны эхний хагас жилийн байдлаар 1 хүсэлт/ гомдол гарсан.

1. Гомдол/ хүсэлтийг хэлбэрээр нь:

- Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны хоорондын ёс зүй харилцаа, хандлагын зөрчилтэй холбоотой -1

Гомдлын шалтгаанд дүн шинжилгээ хийж, ажилчдын орлон гүйцэтгэх тушаалыг шинэчлэн ажлын цаг ашиглалтыг зохицуулж 100 % эерэгээр шийдэгдсэн.

Арван зураа. Шинэ ажилтанг чиглүүлэх сургалтын хөтөлбөрт чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаар тусгах, эмч, эмнэлгийн ажилтнуудад чанар, аюулгүй байдлын сургалтыг тогтмол зохион байгуулна.

Хүний нөөцийг бүрдүүлэх, нэмэгдүүлэх, чадавхижуулах чиглэлээр төвийн даргын 2024 оны А/18 тоот тушаалаар “Шинээр ажилтан сонгон шалгаруулах журам”, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж батлуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Үүнд: Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, шинэ ажилтныг сонгон шалгаруулах журамын дагуу

- Сонгон шалгаруулалтад оролцогчдын бүрдүүлэх материалын дагуу анкет материалыг хүлээж авдаг
- Материал нь шаардлага хангасан эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ярилцлагад урьдаг
- Удирдлагад танилцуулан туршилтын 3 сарын хугацаагаар ажиллуулдаг.
- Туршилтын хугацааны дараа хамт олны шийдвэрийг удирдлагын багийн хуралд танилцуулж, жинхэнэ ажилтнаар томилдог.
- Шинээр ажилд орж буй ажилтанг 3 сарын туршилтын хугацаагаар ажиллуулж туршилтын хугацаа дуусмагц тухайн ажилтны хийсэн ажлын тайлантай танилцаж цаашид жинхэнэ ажилтан болгох талаар хурал хийж, гарсан шийдвэрийг удирдлагын багийн хурлаар хэлэлцэж, эцэслэн шийдвэрлэдэг.

Сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлаж олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудас, эрүүл мэндийн хөгжлийн төвийн сайтаар дамжуулан Сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалтын ажлын байрны зарыг ажил албан тушаалын тодорхойлолтын дагуу тус тус гаргаж байршуулдаг. Тус журмын дагуу сонгон шалгаруулалтад тэнцсэн ажил горилогчийг хөтөлбөрийн хүрээнд шалгаруулж сонгох ба тэнцсэн ажилтныг ажлын байранд дасан зохицох, сургах, дадлагажуулах, урамшуулах үйл ажиллагааг зохион байгуулж цаашид тогтвор суурьшилтай ажиллахад анхааран ажиллаж байна.

Төв нь 2026 оны I-р улирлын байдлаар 8 ажлын байранд 5 удаа зарыг боловсруулж, журмын дагуу ил тод, нээлттэй зарлан мэдээлж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан.

Шинэ ажилтанг чиглүүлэх, дадлагажуулах сургалтын батлагдсан хөтөлбөртэй. Төвийн даргын 2026 оны 04 дүгээр сарын 16 -ний өдрийн А/13 тоот тушаалаар “Шинэ ажилтны чиглүүлэх, дасан зохицох хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулан батлав.

Сургалтыг хөтөлбөрийн дагуу Шинэ ажилтныг чиглүүлэх сургалт нь дараах хөтөлбөр, агуулгын хүрээнд зохион байгуулагддаг. Үүнд:

- Байгууллагын танилцуулга
- Удирдлагын танилцуулга
- Төвийн бүтэц, зохион байгуулалт
- Бичиг хэрэг хөтлөлт болон архивын үйл ажиллагаа

- Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”, хөдөлмөрийн гэрээ
- Халдвар сэргийлэлт, хяналтын үйл ажиллагаа
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй сургалт
- Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөлтийн журам
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, дүрэм стандарт
- Эмнэлгийн дотоод сүлжээ ашиглалт болон эмнэлзүйн программ ашиглалт

2026 оны эхний хагас жилд 6 ажилтан шинээр орж ажилласан бол үүнээс 1 их эмч, 1 сувилагч, 1 мэргэжилтэн, 3 гэрээт ажилтан захиргаанд шинээр орсон. Шинээр ажилд орж буй ажилтнуудтай Хүний нөөцийн менежер биечлэн уулзаж, бүрдүүлэх материал, анхаарах асуудлууд, эрх зүйн зохицуулалтуудын талаар танилцуулан асуултанд хариулж, тайлбарлан нээлттэй ярилцаж, зөвлөгөө, зааварчилгааг өгч хэвшсэн. Үүний үр дүнд байгууллагын талаар цэгцтэй ойлголттой болж, богино хугацаанд дасан зохицож, хамт олны нэг хэсэг болж чадах ба цаашлаад хүний нөөцийн тогтвортой байдлыг бүрдүүлсэн.

Мөн ёс зүй, харилцаа хандлага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажиллагаа болон халдвар хамгааллын чиглэлээр баримтлан ажиллах нэгдсэн ойлголттой болдог.

Арван долоо. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, өөрийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын үйл ажиллагааг үнэлнэ.

ХҮҮХДИЙН СЭРГЭЭН ЗАСАХ ХАН ТУУЛ ТӨВИЙН ЧАНАРЫН

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ- 2026

I улирал

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Үнэлгээ
А.НИЙТЛЭГ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ			
1	Эмнэлзүйн зааврын хэрэгжилт	Тоо/хувь	
2	Түгээмэл үйлдлийн стандартын хэрэгжилт	Хувь	79%
3	Орны фонд ашиглалтын хувь	Нийт ор хо*100/12с*30х %	5.9%
4	Дундаж ор хоног	Нийт ор хо/ Эмчлүүлсэн хүний тоо	12.8
5	Хэвтэн эмчлүүлэгчийн нас баралтын хувь	Хувь	/-/
6	Тусламж үйлчилгээтэй холбоотой гарсан алдах дөхсөн тохиолдлын тоо	Тоо	8

7	Эмнэлгийн мэргэжилтний мэргэжил олгох, дээшлүүлэх сургалт	Тоо	4
8	Мэргэжлийн зэрэг цол хамгаалсан эмч, мэргэжилтний тоо	Мэргэжлийн зэрэгтэй хүний тоо / нийт ажилтнуудын тоо	/-/
9	Тусламж үйлчилгээнд хэрэгжүүлсэн шинэ стандарт, эмнэлзүйн удирдамж хэрэгжилт	Тоо	/-/
10	Тусламж үйлчилгээнд хэрэгжүүлсэн сайн туршлага, эмчилгээний шинэ арга технологи нэвтрүүлэлт	Хувь	1
11	Тусламж үйлчилгээний нотлогдсон гомдлын тоо	Тоо	/-/
12	ЭТҮХХ-н хувь	Хувь	/-/
13	Эрүүл мэндийн ажилтны гарын ариун цэврийн мөрдөлтийн хувь	Тоо/Хувь	64/80%
14	ЭМБ-аар үйлчлүүлэхдээ унаж гэмтсэн тохиолдол	Тоо	/-/
15	Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн хувь	Хувь	94,9%
16	Урьдчилан сэргийлэх үзлэг	Тоо	313
17	Хоолны технологи, картны тоо	Тоо	65
18	Ажилчдын сэтгэл ханамжийн судалгаа	Хувь	68%
Б.ӨВӨРМӨЦ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ			
1	Сэргээн засахын тоног төхөөрөмжийн хангалт	Тоо	2
2	Хөдөлгөөн засал эмчилгээний эдгэрэлт, сайжралт	Хувь	56%
3	Хэл засал эмчилгээний эдгэрэлт, сайжралт	Хувь	62%

Арван найм. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр тухайн байгууллагад мөрдөх дүрэм, журам заавар, хяналтын хуудсыг хуульд нийцүүлэн боловсруулан, мөрдүүлж, хэрэгжилтийг ханган ажиллана.

№	Шинээр боловсруулсан удирдамж зааврын нэр	Ажилчдад танилцуулах талаар хийсэн үйл ажиллагаа хамрагдсан хүний тоо
1	Яаралтай тусламжийн шүүгээний бэлэн байдлын хяналтын хуудас	6 эмч 5 сувилагч
2	Цахим өвчний түүх бичилтийн хяналтын хуудас	4 эмч

Арван ёс. Эрүүл мэндийн мэргэжилтний ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд чанар аюулгүй байдлын ажлыг нэг шалгуур болгон оруулж дүгнэнэ.

1. Магадлан итгэмжлэлийн шинжээчийн зөвлөмжийн дагуу 2026 оны Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн албаны зөвлөлийн 2025 оны шинэчилсэн тогтоолыг тус тус үндэслэн төвийн нийт ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж Чанар, аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагаанд төвийн нийт ажилтны оролцоо, оролцох чиг үүргийг тусгаж нийт 36 ажилтнуудад танилцуулан батлуулсан.

Байгууллагын дүрэм, бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай НЭМГ-ын даргын 2024 оны А/36, Төвийн даргын 2022 оны Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлах тухай А/11, Төвийн даргын 2026 оны А/04, А/05, А/06, А/07 тоот тушаалуудыг тус тус үндэслэн албан тушаалын тодорхойлолтыг ажилтан тус бүрээр шинэчлэн баталгаажуулсан.

2.Төвийн даргын 2022 оны 11 сарын 11-ны А/59 тоот “Ажил дүгнэх байнгын комисс байгуулах тухай” тушаалын нэгдүгээр хавсралт – Ажил дүгнэх байнгын комиссын бүрэлдэхүүн, хоёрдугаар хавсралт-Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөлт, биелэлтэнд хяналт шинжилгээ үнэлгээ хийх журам,гуравдугаар хавсралт- Улирлын ажлын гүйцэтгэл ,үр дүнгээр урамшуулал олгох шалгуур үзүүлэлт, дөрөвдүгээр хавсралт- Ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт, тавдугаар хавсралт-Оны шилдэг ажилтан, алба шалгаруулах журам тушаалаар баталсан. Тус тушаалын гурав, дөрөвдүгээр хавсралтанд нийтлэг-7 шалгуур , тусгай-3 шалгуур ажил дүгнэх шалгуурт оруулсан. Эмнэлгийн мэргэжилтэн, бусад ажилтны ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд ЧАБ-ын чиглэлээр хийсэн ажил, үйлчилгээний чанартай холбоотой ёс зүй харьцаа, хандлагын байдал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой эмчилгээ үйлчилгээний заавар, удирдамж, стандартыг мөрдөж байгаа байдал, хариуцсан ажлын чанартай холбоотой үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар гэсэн шалгуурууд орсон.Чанарын менежер сар бүрийн ажил дүгнэх үйл ажиллагаанд үр дүнтэй ажилласан ажилтнуудад урамшуулал олгоход санал дэвшүүлж оролцдог.

Хорь. ЭМТҮЧАБ-ын алба нь тасаг/нэгжүүдэд чанар, аюулгүй байдлын баг байгуулж ажиллах талаар : ЭМТҮЧАБ-ын баг нь тасаг/нэгжүүдэд чанар, аюулгүй байдлын баг байгуулж ажиллах талаар

НЭМГ-ын даргын 2024 оны 04-р сарын 02-ний өдрийн А/36 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан Нийслэлийн хүүхдийн сэргээн төвийн бүтцэд ЭМТҮЧАБА-гүй зөвхөн чанарын менежер ажиллах юм. 2025 оны 10 дугаар 01-ны төвийн даргын тушаалаар албажин чанарын менежерийг хавсран гүйцэтгэж байна.

Дүгнэлт: ЭМТҮЧАБ-ын үйл ажиллагааг сайжруулах 10 зорилт:

Зорилт 1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, удирдлагын манлайллыг бэхжүүлэх

Зорилт 2. Эмнэлзүйн удирдамж, заавар, стандартын хэрэгжилтийг хангах

Зорилт 3. Эрүүл мэндийн ажилтан болон үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, тусламж үйлчилгээний эрсдлийг бууруулах

Зорилт 4. Тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх

Зорилт 5. Тусламж үйлчилгээний таатай орчин бүрдүүлэх, хэрэглэгчийн үнэлгээг тогтмолжуулах

Зорилт 6. Чанар, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлт боловсруулах, хяналт, шинжилгээ үнэлгээ хийх

Зорилт 7. Сувилахуйн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах

Зорилт 8. Хүний нөөцийг бэхжүүлэх, чадавхижуулах

Зорилт 9. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлагыг сайжруулах

Зорилт 10. Шинэ технологи, сайн туршлага нэвтрүүлэх, тулгамдаж буй асуудлын хүрээнд судалгаа шинжилгээ хийх

ТӨВИЙН ДАРГА:

Х.УЯНГА

Хянасан: Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга:

Ж. Болортуяа

Тайлан бичсэн Чанарын менежер хавсран гүйцэтгэгч :

С. Жаргалзаяа / Сэргээн засахын Их эмч/

Сэтгэл ханамжийн судалгаа 2026 оны 1-р улирал

“Хүүхдийн сэргээн засах Хан Түүл төв”-ийн

Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа 1-3 дугаар сар

Өдрийн эмчилгээ болон Хэвтэн эмчлүүлэх тасгийн үйлчлүүлэгчид / асран хамгаалагч нар/ -ээс сар бүр сэтгэл ханамжийн судалгааг цаасаар болон асуумжаар, бичгээр, саналын хайрцгаар, онлайнаар, аман болон мэдээллийн утсаар авч гарсан үр дүнг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. 2026 оны 1-р улирлын байдлаар асуумж хуудсаар 6 удаагийн судалгаанд нийт 118 үйлчлүүлэгч, түүний ар гэр асран хамгаалагчдыг хамрууллаа. Үүнд:

1. Хэвтэн эмчлүүлэх тасгийн хүүхэд түүний асран хамгаалагч - 49
2. Өдрийн эмчилгээний кабинетаар үйлчлүүлсэн хүүхэд түүний асран хамгаалагч - 20
3. Хоолтой холбоотой 5 асуумж – 49 тус тус хуудсаар сэтгэл ханамжийн судалгааг авсан.

2026 оны эхний улирлын байдлаар үйлчлүүлэгч түүний ар гэр асран хамгаалагч нараас 5-12 асуумж бүхий 118 хуудсаар судалгааг авсан. Сэтгэл ханамжит байдал - 94,9%.

Санал хүсэлт, талархал, гомдол – 2026 I улирал

Хугацаа	Судалгаанд хамрагдсан хүний тоо				Талархал	Санал хүсэлт	Гомдол	Сэтгэл ханамжит байдал %
1-р улирал	118				28	44/18	0	94,9%
	01 сар	24	Өдөр	8		15	0	<u>Үнэлгээ:</u>

			Хэвтэн	8	8			Маш сайн - 112/ 94,9% Дунд - 6/ 5,1% Муу -0
			Хоол	8				
	02 сар	18	Өдөр	6	9	14	0	
			Хэвтэн	6				
			Хоол	6				
	03 сар	76	Өдөр	6	11	14	0	
			Хэвтэн	38				
			Хоол	32				

Талархалын төрөл:

Хамт олонд – 8

Хоол үйлдвэрлэлд – 4

Хэл засалч- 4

Хөдөлгөөн засалч-2

Хөдөлмөр засалч – 2

Усан эмчилгээ – 2

Иллэг, бариа – 2

Цахилгаан эмчилгээ-2

Туслах сувилагч нарт-2

Сэтгэл ханамжийн судалгаанд гарч буй санал, хүсэлт:

1. Хоол халаах печь, хөргөгчтэй болох – 5
2. Усан эмчилгээнд барагшун, шөл, бор цай гэх мэт төрөл нэмэх – 3
3. Татсан махтай хоол голдуу өгдөг-2
4. Хоолны амт сул-2
5. Хоолны нэр төрөлд тараг сүү оруулах-3

6. Эмчилгээнд орох цаг өгөх, очерлуулахгүй байх – 3
7. Хөдөлмөр засал эмчилгээний цаг уртасгах – 2
8. Хөдөлмөр засалч хүүхэдтэй тулж ажиллах - 2
9. Өрөөг цоожтой болгох – 2
10. Аяга угаах тусдаа хэсэгтэй байх, шатны хамгаалалт хийх – 3
11. Хүүхдийн живх солих ширээ, хоолны ширээтэй болох – 2
12. Сахиурууд усанд орох өрөө – 3
13. Тоглоомын өрөөг тохижуулах – 3
14. 1-р хоолны төрөл сайжруулах, гурил будааг багасгах – 3
15. Хэвтэх хүүхдийг дараагийн удаа өдрийн эмчилгээнд хамруулах – 2
16. Сэтгэл зүйчийн цагийг уртасгаж, асран хамгаалагчид дэмжлэг үзүүлэх – 2
17. Хүүхдийн нойлын суултуур янзлах – 1
18. Өрөөнд олноороо байна, өрөөний зохион байгуулалт дээр анхаарах-1

Үйлчлүүлэгчийн санал, хүсэлтэд дүн шинжилгээ хийж түүний дагуу авсан арга хэмжээ,хийсэн ажлууд:

Хоол үйлдвэрлэл,үйлчилгээ:

- Хэвтэн эмчлүүлэх тасагт хоол халаах печь болон хөргөгчийг байршуулан үйл ажиллагаанд хэрэглэж байна.
- Хоол зүйчийг гэрээт ажилтанаар шинээр авч ажиллуулж байгаа. Хоолны цэс, технологийн картыг шинэчилсэн. Хоолны амт нэр төрөл цөөн гэсэн санал сар бүрийн сэтгэл ханамжийн судалгаанд гарсны дагуу 65 технологийн карт боловсруулагдсан ба орц нормыг мөрдөн ажиллаж байна. Хоолны нэр төрлийг цэсний дагуу боловсруулж /14 хоног/ төвийн даргаар батлуулан нээлттэй самбарт байршуулсан. Хоолны чанар порц,технологид анхаарч өглөө,өдөр оройн хоолонд жижүүр эмч,ХСХ, дотоод хяналтын баг хяналт тавьж санал хүсэлтийн нээлттэй дэвтэр ажиллуулж байна.
- Үйлчлүүлэгийг зөв танин тодруулах журмын дагуу эмчилгээний хоолтой үйлчлүүлэгчид улаан өнгийн бугуйвч зүүн өгч, давхар хоолны мэдээний хуудсаар / ялгах тулгалт, тэмдэглэл хийж,эмчилгээний хоол тус бүрээр ангилж ,нэрсийг цахимтай / Аксис карте/ холбосон.
- Бүтэц өөрчилсөн /тусгай меню/ хоолтой хүүхдүүдэд хоолыг зориулалтын стандарт шилэнд тус тусад нь хийж зөөвөрлөдөг. Мөн жингийн алдагдалтай хүүхдүүдэд 11:00 цагт төрөл бүрийн нухашуудыг мөн зориулалтын стандарт шилэнд хийж хаягжилт хийж тараадаг болсон.Нийт 6 шил шинээр авсан.

- Хоолны нэр төрлийг нэмэгдүүлж шинээр 9 төрлийн хоол /цагаан цэцэгт байцаа, улаан лооль, ногоон хулууны зутан шөлнүүд, тахианы котлет, аньс ,нэрсний шүүснүүд, алим, лууван, улаан лоолийн нухаш/ шинээр цэсэнд оруулж шинэчилсэн.
- Төв нь гэрээт байгууллагаас төмс нарийн ногооны нэр төрлийг нэмэгдүүлэн /өргөст хэмх,улаан лооль,чавга / зэрэг чанартай аюулгүй хүнсний ногоогоор хангаж ажиллаж байна.
- Нарийн боовны бүтээгдэхүүнийг бүхэл үрийн гурилаар баяжуулсан, нэвс зэргээр хийж байна.
- “Ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй” чиглэлээр 2026.03.31-нд сургалт хийгдсэн.
- Хүнсний материалын хадгалалт, хүнсний складын ариун цэвэр, бичиг баримтын баталгаажилт, эрүүл ахуйн дүгнэлт зэргийг графикийн дагуу үзлэг хийж хүлээн авч буй хүнсний материалын үйлдвэрлэсэн болон дуусах хугацаа, гарал үүслийн баталгаажилт эрүүл ахуйн дүгнэлтийг шалгаж хүлээж авч ажиллаж байна.
- Жижүүр эмч орой бүр ЭМБО сургалт болон бусад мэдээлэл хийснээр аман сэтгэл ханамжийн тоо дээшилсэн ба хоолтой холбоотой гарсан санал хүсэлтийг тухай бүрд нь шийдвэрлэх зохицуулалт хийгдснээр хүүхэд тэдний асран хамгаалагч нарын сэтгэл ханамжит байдал дээшилсэн.
Дээрхи бүтээлч ажлуудын дүнд хоолны амт чанар сайжирч сэтгэл ханамжит байдал дээшилж сар бүрийн судалгаанд сайжирсан дүнтэй гарч байна.

Өрөөний тохижилт:

- Хүүхэд хөгжлийн өрөөнд хүүхдийн номын буланг тохижуулахаар KIDS ALL хүүхдийн тавилгын дэлгүүртэй хамтран нийгмийн хариуцлагын хүрээнд төсөл хэрэгжүүлэн явж байна.
- Төвийн 2 талын шатны хэсэгт унах эрсдлээс сэргийлсэн төмөр хаалт хийлгэсэн.
- Гадна их цэвэрлэгээг нийт ажилчид хуваарийн дагуу хийсэн.
- Төв хаалганы хэсгийн ханыг будаж, засварлан шинээр хүүхдийн 8 зураг байршуулсан.
- SUVD art & craft studio-той хамтран 5-10 насны хүүхдүүдийн бүтээлээр төвийн үүдний хэсгийн дотоод тохижилтыг бүрдүүлсэн.
- Төвийн хэмжээнд нийт өрөө тасалгааны 74 хаягжилт хийхээр захиалсан.
- Аяга угаах тусдаа хэсэг үүсгэхээр төвийн селесарь хэмжээ болон үнийн саналыг гарган ажиллаж байна.

Тусламж үйлчилгээтэй холбоотой:

- Усан эмчилгээний нэр төрөл нэмэгдүүлэх зорилгоор бор цайнд оруулж эхэлсэн.

- Өдөр болон хэвтэн эмчлүүлэх эмчилгээний цаг, оочер, зохицуулах, сэтгэлзүйчийн зөвлөгөөний цаг уртасгах ажлын хүрээнд удирдлагад танилцуулж хүний нөөцтэй холбоотой санал оруулсан байгаа.
- Нэг өрөөнд олноороо байгаа зохион байгуулалт болон сахиурууд усанд орох өрөөг удирдлагын зөвлөлд танилцуулан судалгааг хийлгэж байна.
- Хэвтэн эмчлүүлэх болон сахиурын мөрдөх журмыг шинэчилэн батлуулсан.

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харьцаа хандлага:

- Үйлчлүүлэгчдээс ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой гомдол гараагүй.

Дүгнэлт: 2026 оны 1-р улиралд нийт 44 санал / давхардсан тоогоор/ 18 төрлийн санал хүсэлт гарсанаас 13 төрлийн ажил хийгдсэн байна. Биелэлт -72,2%. Үүнээс 5 төрлийн ажил хийгдээгүй. Эдгээрийг хийх ажлын төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

Ч/М- С.Жаргалзаяа